НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2026.09.14 Улаанбаатар хот

Зорилго: Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг ажил олгогчид, иргэд, даатгуулагчид, олон нийтэд сурталчилах, нийгмийн даатгалын байцаагч, ажилтнуудыг мэдээллээр хангахад оршино.

Арга хэмжээний нэр: Нийгмийн даатгалын багц хууль, Нийгмийн даатгалын даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, холбогдох журам, дүрэм, зааврын эмхэтгэл бэлтгэх, түгээх;

Нэмэлт мэдээлэл, бүрдүүлэх материал:

Үнийн санал ирүүлэх байгууллага	-Хэвлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага;
Гүйцэтгэх ажил	-“Нийгмийн даатгал” гарын авлага-3,230 ширхэг; -Эх бэлтгэл; -Хэвлэл; (Ажлын даалгаврыг хавсаргав)
Гүйцэтгэх хугацаа	Гэрээ байгуулснаас хойш 5 өдрийн дотор;
Бүрдүүлэх материал	-Дараах баримт бичгийг бүрдүүлж ирүүлнэ. • Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ; • Ажил гүйцэтгэх үнийн санал; • Энэ чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын туршлага, байгууллагын танилцуулга.

Үнийн санал, холбогдох материалыг 2026 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 17 цагаас өмнө доорх хаягаар болон **undeg@ndaatgal.mn** цахим хаягаар ирүүлнэ үү.

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Бага тойруу 13/1, Нийгмийн даатгалын ерөнхий газар;

Утасны дугаар: 328030-304;

---///---